



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,

Утас: (976) 7032 3260,

Цахим шуудан: Nature@ov.gov.mn, Uvurkhanga.nature@gmail.com,

Цахим хуудас: www.nature.ov.gov.mn

2025. 12. 12 № 886
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭСТ

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Байгаль орчны газрын 2025 оны
гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж
хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 1.5 хуудастай

ДАРГА



Т.ЭРДЭНЭБАЯР



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ БАЙГАЛЬ ОРЧНЫ
ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2025 он

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт
НЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД						
Зорилт 1.1 Уялдаа: АЗДҮАМХ		Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллана.				
1.1.1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах;	-	Чанар, үр дүн, хэрэгжилтийн хувь, хугацаандаа тайлагнасан байдал;	88,2	Салбарт хамаарал бүхий зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж, холбогдох газруудад тайлагнасан байна.	-Байгаль орчны салбарын бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт, хөтөлбөрүүдийн салбарт хамаарах зорилт арга хэмжээний биелэлтийг тухай бүр гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлж тайлагнасан. ЗДТГ-ын ХШҮХэлтсээс ирүүлсэн зөвлөмжийн дагуу байгууллагын 2025 оны гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулж газрын даргаар батлуулан мэргэжилтнүүдийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллалаа.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг улирал бүр гаргаж холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Хэрэгжилт-100 хувь
1.1.2	Байгаль орчны багц хууль, тогтоомж, дүрэм, журам шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт шалгалт, тооллого судалгааны ажил зохион байгуулах	20,0	-Хяналт шалгалтын дүнд илрүүлсэн зөрчлийн тоо -Урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ;	25	-Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах -төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны салбарын хяналтын газраас баталсан 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 7 удирдамжийн хүрээнд зохион байгуулж 100 зөрчлийн гомдол мэдээллийг шалгаж 81 зөрчилд 53.2 сая төгрөгийн торгууль оногдуулж, байгальд учирсан хохирлын 73.5 төгрөг нөхөн төлүүлж шийдвэрлэлээ. Гэмт хэргийн шинжтэй 6 үйлдлийг цагдаагийн байгууллагад, харьяаллын дагуу, бусад байгууллагад 10

						зөрчлийг шилжүүлж, 1 зөрчлийг хүлээн авахаас татгалзаж, 2 зөрчлийг шалгаж байна. Цаг үеийн шинж чанартай орон нутгийн онцлогт тохирсон хяналт шалгалтуудыг тухай бүр зохион байгуулж ажилласан. -Хайрхандулаан сумын 4 дүгээр багийн нутаг, Зангатын хоолой гэх газарт 2024 оны 12 дугаар сараас эхлэн аймгийн Цагдаагийн газар, Хайрхандулаан сумын ЗДТГ-тай хамтран хууль бусаар ашигт малтмал эрэх, хайх, олборлох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт 40 удаа зохион байгуулж, гэмт хэргийн шинжтэй 7 үйлдлийг цагдаагийн газар мөрдөн шалгаж байна. -2025 оны 2-4 дүгээр саруудад Арвайхээр сумын дулаан үйлдвэрлэгч аж ахуй нэгж байгууллагуудад, 2 дугаар сард мод бэлтгэлийн үйл ажиллагаанд, 5-6 дугаар сард хог хаягдал орчны бохирдол, рашаан сувиллуудын ус ашиглалтын байдалд, 7-10 дугаар саруудад байгалийн дагалт баялаг түүж бэлтгэх, хууль бус ан агнуур, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллагуудын нөхөн сэргээлт, ус ашиглалтын байдалд тус тус хяналт шалгалтуудыг тухай бүр зохион байгуулж ажилласан. -Ой хээрийн түймэр гарах эрсдэл бүхий 3-6, 9-10 дугаар саруудад ой бүхий сумдын Засаг даргын Тамгын газар, сум дундын Ойн анги, аймгийн Онцгой байдлын газартай хамтран ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажил, ой бүхий газарт хаваржиж байгаа айл өрхүүдтэй хариуцлагын гэрээ
--	--	--	--	--	--	--

						байгуулж ажилласны үр дүнд ой хээрийн түймэр гараагүй. -Хяналт шалгалтын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 273 заалт бүхий 53 улсын байцаагчийн албан шаардлага, 17 заалт бүхий улсын байцаагчийн 4 зөвлөмжийг холбогдох иргэн байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллалаа. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 20,0 сая төгрөг төлөвлөж, албан хаагчдын томилолт, шатахуун, урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээнд зарцууллаа. Хэрэгжилт-100 хувь
1.1.3	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, дагалдах журмын хэрэгжилтийг хангаж, хуулийн хэрэгжилтийг 100 хувьд хүргэж нэмэгдүүлэх;	-	Хуульд заасан хувь хэмжээгээр	85%	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02/12 дугар тогтоолын 6 дугаар хавсралтаар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 247,3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, нийт 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Уг зардлаар хийгдсэн ажлын тайланг 2025 оны 11 сард аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, хэрэгжилт 99,1 хувьтай дүгнэгдсэн. Хэрэгжилт-100 хувь
1.1.4	Орон нутгийн суурь зардалд туссан байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тусдаа хавсралтаар ИТХ-аар батлуулах; (газар, ой, амьтан, ургамал, ус рашаан.)		Аймаг, сумын ИТХ-ын тогтоолуудыг нэгтгэх	-	19 сум	Аймгийн хэмжээнд 19 сум байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хэсгийг тухайн нөөцийг хамгаалах чиглэлийн арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөгөөг боловсруулж, аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор нийт 1,897,798,040 мянган төгрөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Хэрэгжилт 100 хувь

1.1.5	2025 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувь хэмжээ, орлогын хэсгээр зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг Байгаль орчны төсөв зардлын мэдээллийн санд журамд заасан хугацаанд оруулах (www.eic.mn);	-	Оруулсан мэдээллийн тоо	100%	Журамд заасан хугацаанд мэдээллийг бүрэн оруулах	2025 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувь хэмжээ, орлогын хэсгээр зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг журамд заасан хугацаанд буюу 2025 оны 01 дүгээр сарын 20-ны дотор Байгаль орчны төсөв зардлын мэдээллийн санд батлагдсан маягтын дагуу шивж оруулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Хэрэгжилт-100 хувь
1.1.6	Яамнаас бэлтгэсэн сургагч багш нараар БНАТХууль, дагалдах журам болон мэдээллийн сангийн сургалт зохион байгуулах;	-	Зохион байгуулсан сургалт, цахим сургалтын тоо, оролцогчдын тоо	5	3-аас удаа доошгүй	-2025 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувь хэмжээ, зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг бүрэн гүйцэд үнэн зөв, журмын дагуу төлөвлөж оруулах талаар сумдад албан тоотоор чиглэл, зөвлөмж хүргүүлсэн. Сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын нэгдсэн сургалтыг 2025 оны 1 сард зохион байгуулж, 2024 оны тайлан болон 2025 оны төлөвлөлтийг байгаль орчны төсөв мэдээллийн санд журамд заасан хугацаанд оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. -Газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 3,5,9,12 дугаар сард бүх сумдыг хамруулан дотоод хяналт шалгалт зохион байгуулж, сумдын удирдлагууд болон холбогдох албан хаагчдад Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын талаар сургалт зохион байгуулж, сумдад 2025 онд хийгдсэн ажил болон 2026 оны арга хэмжээний төлөвлөлт, байгаль орчны төсөв мэдээллийн сангийн программын ашиглалтад хяналт үнэлгээ хийж, мэргэшил

						арга зүйгээр хангаж зөвлөн туслах ажил зохион байгууллаа. -2026 оны орлогын төлөвлөлт болон арга хэмжээний төлөвлөгөөг БНАТ-1, БНАТ-2А, БНАТ-3 маягтын дагуу WWW.EIC.MN байгаль орчны төсөв мэдээллийн санд шивж оруулах талаар сумдад чиглэл хүргүүлсэн. Хэрэгжилт-100 хувь
1.1.7	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29 ¹ .1.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх	-	Ажлын гүйцэтгэл	-	100%	-Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус газраас Байгаль орчны хяналтын улсын байцаагчдыг хяналт шалгалт, явуулахад шаардлагатай унаа, техник хэрэгсэл, дүрэмт хувцсаар ханган ажиллах нөхцөлийг сайжрууллаа. -Байгаль орчин, уур амьсгалын яамнаас хэрэгжүүлж буй БОЯБХУАӨДЗохих төслийн хүрээнд Байгаль орчны газрын мэргэжилтнүүд, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, сумдын Байгаль хамгаалагч нарыг 4 улирлын дүрэмт хувцас, аяны гудас, мишок, майхан, гар чийдэн, повер банк, үүргэвч зэрэг техник хэрэгслээр бүрэн хангагдаж, уг арга хэмжээнд төслөөс 80,8 сая төгрөг зарцуулсан байна. -Аймгийн Байгаль орчны газар нь тусгай зориулалтын ангийн дуудлага худалдаанаас орсон орлогоос байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, хяналт шалгалт явуулахад шаардлагатай туулах чадвар сайтай автомашин худалдан авах тендерийг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж Ланд-200 маркийн автомашин худалдан авч хяналтын ажилд ашиглаж байна. Хэрэгжилт-100 хувь
1.1.8	Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт явуулахад шаардлагатай техник	-	Хангасан техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тоо	-	-	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 11,5 сая төгрөгөөр албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, хяналт шалгалт явуулахад

	хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах					шаардлагатай 2ш компьютер 3ш принтер, 1ш зургийн аппарат авч техник тоног төхөөрөмжөөр хангасан. Хэрэгжилт-100 хувь
						-Зэрлэг амьтдын аюулгүй байдлыг хамгаалсан төмөр замын шинэ хориг хашааны MNS 7042:2024 стандартыг 2025 оны 05 дугаар сард зохион байгуулсан сумдын нэгдсэн сургалт дээр сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдад танилцуулж сум орон нутагт мөрдлөг болгож ажиллах талаар үүрэг чиглэл өгч ажилласан. 2025 онд агнуурын бүс нутаг бүхий сумдад дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил хийгдээгүй болно. Хэрэгжилт-70 хувь
1.1.9	Шугаман дэд бүтцийн бүтээн байгуулалтад зэрлэг амьтанд ээлтэй гарц, гарам, хашааны стандартыг мөрдүүлэх, хяналт тавих	-	Стандарт мөрдүүлсэн арга хэмжээний тоо		2	
1.1.1 0	Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр энгийн болон аюултай хог хаягдал хадгалах, ашиглах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх	-	Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо	8	5	Энгийн болон аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу 2025 оны 3 дугаар сарын 18-наас 5 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулав. Хяналт шалгалтад Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, "Чинмэнд" эмнэлэг, "Ариунсанаа" эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Есөнзүйл, Баян-Өндөр, Сант, Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Богд, Тарагт сумдын эрүүл мэндийн төв, Хархорин сум дахь "Авто замын засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК-ийн салбар, мөн зориулалтын бус цэгт үүссэн үүсмэл хогийн цэгүүдийг хамруулан шалгалт хийв.

						Хяналт шалгалтын явцад аюултай хог хаягдлыг ил задгай шатаахгүй байх, зориулалтын шатаах зууханд шатаах, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг холбогдох газраар хийлгүүлэх, эх хүүхдийн эрүүл мэндийн сангаас нийлүүлэгдсэн автоклавыг яаралтай ашиглалтад оруулах талаар заавар зөвлөгөө өгч ажиллалаа.
						"Авто замын засвар арчлалтын нэгтгэл төрийн өмчит хувьцаат компаний харьяа Хархорин сум дахь салбарын ажилтан албан хаагчдын ахуйн болон аюултай хог хаягдлын талаар ойлголт, мэдлэг дутмаг байсан тул албан хаагчдыг чадавхжуулах сургалтад хамруулах, аюултай хог хаягдлыг түр хадгалах цэгтэй болох, Хархорин сумын нутаг дэвсгэрт зориулалтын бус гурван цэгт хуримтлагдсан үүсмэл хогийг цэвэрлэх талаар холбогдох байгууллагад хугацаатай албан шаардлага хүргүүлж, зориулалтын бус цэгт үүссэн 10 хогийн цэгийн хог хаягдлыг цэвэрлүүлээ. Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар нийт 18 аж ахуйн нэгж, байгууллагад 90 заалт бүхий хугацаатай улсын байцаагчийн 18 албан шаардлагыг хүргүүлж, 5 иргэнд 170.0 мянган төгрөгийн торгууль оногдуулж шийдвэрлэлээ. Хэрэгжилт-100 хувь
1.1.1 1	Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээ, байгалийн нөөцийн ашиглалт хамгаалалтын талаарх иргэд олон нийтийн	20.0	Зохион байгуулсан арга хэмжээ, сургалт сурталчилгааны тоо	-	10-аас доошгүй сургалт,	Дэлхийн Ойн өдөр, Усны өдрийн хүрээнд Хархорин сумын ЕБС-ийн 9-12 дугаар ангийн сурагчдад Байгаль орчны багц сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад нийт 150 гаруй сурагчид хамрагдаж идэвхтэй оролцсон сурагчдыг урамшууллаа. Хархорин сумын ЕБ-ын сургууль, Мэргэд лаборатори, Тэмүүлэл-Эрдэм сургуулийн сурагчдад "Ус

	мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;				нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.	хаанаас ирдэг вэ?" сургалт, эко аялал, Сант,Төгрөг сумдын ЕБС-ийн сурагчид, төрийн албан хаагчдад Уур амьсгалын өөрчлөлт, Байгаль орчны салбарын хууль эрх зүйн орчны талаарх сургалтыг тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 500 орчим иргэн хамрагдсан. Тус газраас 2025 онд "Мөнх криетив дата" ХХК-тай хэвлэлийн гэрээ байгуулж МНТВ, UNN -телевизүүдээр дамжуулан цаг үеийн мэдээллийг тухай бүр дамжуулан байгаль орчны хууль тогтоомж, мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж ажиллаж байна. "Мод тарих аргачлал сэдэвт 3 видео, 5 зорилтот нэвтрүүлэг, мод бут тарих 2 зөвлөмж, мод услах хуваарь, ан амьтдын экологи эдийн засгийн үнэлгээ болон хог хаягдал байгальд шингэх хугацааны мэдээллээр постер мэдээлэл тогтмол бэлтгэн байгууллагын Фейсбүүк хуудсанд байршуулсан. Аймгийн хэмжээнд 2025 онд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаарх иргэд олон нийтийн 1 удаагийн чуулган, 26 удаагийн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулсан байна.
						Хэрэгжилт-100 хувь
1.1.1 2	Байгаль орчны статистик тайланг /БОХ маягт/-ын мэдээллийг хуулийн хугацаанд холбогдох дээд байгууллагад тайлагнасан байх;	-	Байгаль орчны статистик мэдээ үнэн зөв гарсан байна.	-	100 хувь	Байгаль орчны статистик мэдээ болох 2024 оны "БОХ" тайланг 2025 оны 1 дүгээр сард багтааж батлагдсан маягтын дагуу ойн сангийн өөрчлөлт, нөхөн сэргээлт, ашигт малтмалын нөөцийн өөрчлөлт, ус ашиглалт, хамгаалалт, агнуурын нөөц ашиглалт хамгаалалт, хог хаягдлын чиглэлээр гарган тогтоосон хугацаанд нэгтгэж мэдээллийн сангийн программд http://www.eic.mn/box/login.php хаягаар

						мэдээллийн санд бүртгэх ажлыг 100 хувьтай хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилт-100 хувь
	Зорилт-1.2	Хүний нөөцийн талаарх бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх				
	Арга хэмжээ 1.2.1. Байгууллагын бүтэц орон тоог оновчтой төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд ажиллах, төрийн албан хаагчийг сул орон тоог Төрийн албаны хууль тогтоомжийн дагуу нөхөх		-Батлагдсан бүтэц орон тооны дагуу ажилласан байх; -Хууль бус томилгоо хийгдээгүй байх;		Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах;	-Тус газар нь батлагдсан төсөв, бүтцийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, газрын даргын 2025 оны А/01 тушаалаар албан тушаалын жагсаалт, цалингийн хэмжээг баталж, аймгийн Засаг даргын 2025 оны 03 сарын 31-ний өдрийн А/235 дугаар захирамжаар тус газрын орон тооны хязгаарт өөрчлөлт орсонтой холбогдуулан газрын даргын 2025 оны 03 сарын 31-ний өдрийн А/03 тушаалаар бүтэц орон тоог шинэчлэн баталсан. -Энэ онд тус газрын Ойн нэгжийн дарга, БОХУБайцаагч, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл сумдын байгаль хамгаалагчийн сул орон тоо гарч уг ажлын байрыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөр зарлуулахаар хүсэлтийг илгээж, Төрийн албан хаагчийн хүний нөөцийн удирдлагын системд албан тушаалын тодорхойлолтуудыг цахимжуулах ажлыг Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн чиглэлийн дагуу 2025 оны 04 сарын 01-ний дотор цахим системд шивж оруулсан. Төрийн албаны зөвлөлөөс дээрх албан тушаалын тодорхойлолтуудыг батлах зөвшөөрлийг 2025 оны 10 сард олгож, сул орон тоог нөхөх тусгай шалгалт 12 сард зохион байгуулагдсан. Хэрэгжилт-100 хувь
1.2.1		-		100%		
1.2.2	Арга хэмжээ 1.2.2 Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тохиолдолд Төрийн албаны хууль тогтоомжийн дагуу	-	-Хууль тогтоомжийн хэрэгжилтээр	100%	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Энэ онд тус газрын Газар, газрын хэвлий түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, байгаль орчны үнэлгээ-аудит хариуцсан мэргэжилтнээр Ц.Содномждоржийг өөрийн хүсэлтээр шилжүүлэн томилсон.

	шилжүүлж, нийгмийн баталгааг дордуулахгүй байх;					Хэрэгжилт-100 хувь
	Арга хэмжээ 1.2.3. Аймгийн Засаг даргын 2021 оны А/561 дүгээр захирамжаар батлагдсан "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг ханган ажиллах;	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100%	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, суралцах боломжоор хангаж, нийгмийн баталгааг хангах,	-Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор албаны 2 өрөөнд бүрэн засвар хийж, тохижуулан 4 мэргэжилтний компьютер, техник хэрэгслийг шинэчилсэн. Дээрх арга хэмжээнд байгууллагын төсөв болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 27,5 сая төгрөг зарцууллаа. -Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж, төрийн захиргааны албан тушаалд тасралтгүй 5 жил (60 сар), түүнээс дээш хугацаагаар ажилласан 1 мэргэжилтэнд 5 жилийн тэтгэмж олголоо. Баруунбаян-Улаан сумын байгаль хамгаалагч, БОХУБайцаагч өндөр насны тэтгэвэрт тогтоолгох насанд хүрч, тэтгэмжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгон, өөрийн хүсэлтийн дагуу төрийн албанаас чөлөөлсөн. -Тус газрын мэргэжилтнүүдээс Удирдлагын академийн богино хугацааны төлбөртэй сургалтад 2 мэргэжилтэнг хамруулж, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад газрын дарга болон 1 мэргэжилтэн хамрагдаж төгссөн. Хэрэгжилт-100 хувь
1.2.3	Төрийн албан хаагчийн шагнал урамшууллыг ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулах олгох;	-	Холбогдох хууль тогтоомжийн дагуу	100%	Ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж дүгнэн төсвийн боломжид тулгуурлан урамшуулал өгөх, шагналд тодорхойлох	-Тус газрын мэргэжилтнүүд, сумдын байгаль хамгаалагч нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, биелэлтийг үнэлж дүгнэн "Хангалттай сайн" үнэлгээ авсан албан хаагчдад эхний хагас жилийн үр дүнгийн урамшуулал олгосон. -Энэ онд тус газрын Усны нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Даваацэрэн Засгийн газрын шагнал Байгаль орчны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан.

						Хэрэгжилт-100 хувь
	Зорилт 1.3 Уялдаа: АЗДҮАМХ	Ойн нөөцийг ашиглалт, хамгаалалт, "Тэрбум мод" хөдөлгөөнийг өрнүүлж, зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд:				
1.3.1	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах;	-	"Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд тарьсан модны тоо, ургалтын хувь	345852	400.0000 мянган мод тарьсан байх	2025 оны хаврын мод тарих өдрүүдээр шинэ Хархорум хотод 700,0 мянга, бусад 18 суманд 590,0 мянган ширхэг мод, намрын мод тарих өдрүүдээр 69,0 мянган ширхэг мод тус тус тарьсан бөгөөд мод тарих ажилд улс, орон нутаг, хувийн хэвшлийн санхүүжилтээр 5,4 тэрбум төгрөг зарцуулсан байна. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, хаврын мод тарих өдрүүдийн хүрээнд Байгаль орчны газар, Богд сумын ЗДТГ-тай хамтран Богд сумын Морины шүтээн цогцолбор 2 га талбайд 5000 гаруй хайлаас тарьж говийн бүс нутагт нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлсэн. Арвайхээр, Тарагт, Зүүнбаян-Улаан, Баруунбаян-Улаан, Хужирт, Хархорин, Бат-Өлзий зэрэг сумдад үйл ажиллагаа явуулж байгаа мод үржүүлгийн газруудад нийт 20 гаруй нэр төрлийн 6,2 сая орчим тарьц суулгац ургаж байгаагаас жилд дунджаар 2,0 сая орчим тарьц суулгацыг ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтэд шилжүүлэх боломжтой болж өөрийн аймгийн хэрэгцээг бүрэн хангах боломжтой болсон. Хэрэгжилт-100 хувь
1.3.2	Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж бий болгох	-	Нийтийн хэрэгцээний ногоон байгууламжийн хэмжээ	216 га	5 га	Аймгийн хэмжээнд төв суурин газрын ногоон байгууламжийг 6 га талбайгаар нэмэгдүүлсэн. Үүнд: Арвайхээр хотын Өлзийтийн 4 дүгээр багт 4 га газарт шинээр цэцэрлэгт хүрээлэн байгуулж, 3000 гаруй мод тарьсан. Арвайхээр хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хот тойрсон уулын ландшафтыг хөгжүүлэх зорилгоор "Баяннамсрай", "Өлзийт", "Их монгол" зэрэг цэцэрлэгт хүрээлэнгүүдэд тарих модны тоо, төрөл зүйлүүдийг нэмэгдүүлж мод бут

						тарьсан. Хаврын мод тарих өдрүүдийн хүрээнд Байгаль орчны газар, Богд сумын ЗДТГ-тай хамтран Богд сумын Морины шүтээн цогцолбор 2 га талбайд 5000 гаруй хайлаас тарьж говийн бүс нутагт нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлсэн. Хэрэгжилт-100 хувь
1.3.3	Тариалангийн талбайг хамгаалах ойн зурвас байгуулах	-	Тариалангийн талбайг хамгаалах ойн зурвасын хэмжээ	-	15 га	Төгрөг сум Өрхийн тариалан бизнес хөгжил ТББ-аас төсөл хэрэгжиж байгаа тариалан эрхлэгчдийн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах зорилгоор 110 ширхэг улиас, хайлаас "Арцат цагаан" хоршоо 108 ширхэг нийт 218 мод тарьж хамгаалалтын ойн зурвас байгуулаад байна. Хэрэгжилт-75 хувь
1.3.4	Голын татмыг хамгаалах, нөхөн сэргээх	-	Голын татмыг хамгаалах, сэргээсэн нөхөн талбайн хэмжээ	8 га	10 га	Бат-Өлзий сумын Хүйтэн булгийн орчимд Сум дундын Ойн анги, ойн мэргэжлийн 7 байгууллага, 10 нөхөрлөл хамтран 2025 оны 05 дугаар сарын 17-25-ны өдрүүдэд 5 га талбайд 7100 мод тарьж голын татмыг нөхөн сэргээсэн. Онгийн гол дагуу 40 га талбайд татмын ойжуулалт хийх ажлыг эхлүүлж 2025 онд хамгаалалтын хашааг барьсан. Хэрэгжилт-100 хувь
1.3.5	Авто замын хамгаалалтын ойн зурвас байгуулах	-	Авто замын хамгаалалтын ойн зурвасын хэмжээ	30 га	15 га	Зэвсэгт хүчний 256 дугаар анги хамтран мод тарих намрын өдрүүдийн хүрээнд 2025 оны 10 дугаар сард Арвайхээр-Улаанбаатар чиглэлийн авто зам дагуу 1000 ширхэг мод тарих ажлыг зохион байгууллаа. Хэрэгжилт-70 хувь
1.3.6	Жимсний аж ахуй байгуулах		Жимсний аж ахуй байгуулсан талбайн хэмжээ	844 га	5 га	Уянга сум "Зулзган ой" төслийн хүрээнд 45 өрхөд Өрөл, тэхийн шээг 90 гаруй жимсний мод үнэгүй олгож жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүллээ. 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Арвайхээр сумын зүлэгт 12 дугаар багийн шугаман бүжгийн "Айзам" хамтлагийн ахмадууд дайргын голд

						3 га талбайд өрөл, монос, чацаргана зэрэг жимсний мод тарьж төгөл байгуулсан. Хэрэгжилт-70 хувь
1.3.7	Агро ойн аж ахуй байгуулах		Агро ойн аж ахуй байгуулсан талбайн хэмжээ	-	15 га	Хүлэмжийн цогцолборын хаврын тариалалтын бэлтгэл ажлыг хангаж, агро ойжуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн 113-р цэргийн ангитай хамтран 1200 ширхэг хайлаас, Арвайхээр сумын ахмадын хороотой хамтран бургас, өрөл, далан хальс, монос зэрэг 220 мод тарьсан. Хэрэгжилт-70 хувь
1.3.8	Доройтсон ойг нөхөн сэргээх		Доройтсон ойг нөхөн сэргээсэн талбайн хэмжээ	106 га	50 га	2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 га, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр Бат-Өлзий сумын Дээд Бадай гэх газар 15 га, нийт 25 га талбайд доройтсон ойд нөхөн сэргээлтийн ажлыг 42,0 сая төгрөгөөр таван аж ахуйн нэгж хийсэн. Хэрэгжилт- 100 хувь
1.3.9	Байгалийн сэргэн ургалтад туслах		Талбайн хэмжээ	50 га	30 га	Бат-Өлзий сумын Урд агуйтад аж ахуйн нэгжийн хөрөнгөөр 2025 оны 05 дугаарын 18-25-ны өдрийг хүртэл хугацаанд 10 га талбайд "Норд роуд" ХХК байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилт-50 хувь
1.3.1 0	Говь, хээрийн бүсийн ойжуулалт		Говь, хээрийн бүсэд ойжуулалт хийсэн талбайн хэмжээ	10 га	10 га	Говь хээрийн бүсэд ойжуулалт хийх ажлын хүрээнд Байгаль орчны газар Баруунбаян-Улаан суманд 4 га талбайд навчит модны суулгацаар мод тарих ажилд дэмжлэг үзүүлж "Алтан нуга даваа" хоршоо 2025 оны 06 дугаар сарын 09-11-ны өдрүүдэд тус сумын ЗДТГазар, албан байгууллагууд, иргэдтэй хамтран хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилт-70 хувь
1.3.1 1	Сум дундын Ойн анги, мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлэх.	15,0	Дэмжлэг үзүүлсэн эсэх	-	-	2025 онд Бат-Өлзий сумын Өвтийн аманд шинээр байгуулж буй 8 га талбай мод үржүүлгийн газарт тарих модлог ургамлын үр авах арга хэмжээнд тус газраас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 15,0 сая төгрөгийн

						дэмжлэг үзүүлж, гэрээнд заасан ажил төлөвлөгөөний дагуу бүрэн хийгдлээ. Энэ онд шинээр 130 кг шинэс, Хуш 20 кг, цацаргана 20 кг, агч 2 кг, голт бор 5 кг, гүйлс 5 кг, шар хуайс 13 кг, монос 5 кг, бүйлс 5 кг, өрөл 5 кг, долоогоно 1 кг нийт 211 кг үрээр тарилт хийсэн. Хэрэгжилт-100 хувь
1.3.1 2	Томоохон сумдын төв суурин газрын ногоон байгууламжид тооллого, судалгаа хийх, хаягжуулах, төлөвлөлт хийх	9,0	Судалгаа хийгдэж хаягжилт хийгдсэн байх	-	5 сум	Төсвийн тодотголоор төсөв татагдсан.
1.3.1 3	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод бут тарих, ойн зурвас байгуулах ажлын хашаа хамгаалалт, усалгааны систем авах	35,0	Хашаа хамгаалалт, усалгааны систем	-	1	Төсвийн тодотголоор төсөв татагдсан.
1.3.1 4	Төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтарч мод бут тарих, ойжуулалт, ойн зурвас байгуулах, иргэд олон нийтэд экологийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	18,0	Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээний тоо	-	10-аас доошгүй	Аймгийн Байгаль орчны газраас Арвай сургалтын төвтэй хамтарч мод тарих хавар, намрын өдрүүдээр сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид, Сум дундын Ойн ангийн ажилтнуудад 2 удаа, ойн мэргэжлийн байгууллага, мод үржүүлгийн газруудын ажилтнуудад 1 удаа, иргэд өсвөр үеийнхэнд зориулсан сургалтыг 3 удаа тус тус зохион байгуулж 300 гаруй иргэдэд мод бут тарих арчлах, тогтвортой хөгжлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан. БОУАӨЯ-аас "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод бут тарих иргэд олон нийтийн санаачилгыг дэмжих зорилгоор зарласан "Хашаандаа 5 мод тарья" аяны хүрээнд Арвайхээр сумын 1, 8, 9, 13 дугаар баг, Уянга сумын 3,8 дугаар багийн 100 гаруй өрх 1600 ш мод, аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв 5000 гаруй мод тарьсан. Түүнчлэн "Тэр бум мод" сангаас зарласан мод тарих төсөлд

						Арвайхээр сумын "Их говийн мандах булаг" ХХК шалгарч 7 нэр төрлийн 4000 гаруй модыг Арвайхээр хотын Их монгол цэцэрлэгт хүрээлэнд тарьж арчилж ургуулж байна. Өвөрхангай аймагтай 2010 оноос хамтын ажиллагаагаа эхлүүлсэн Бүгд Найрамдах Солонгос улсын Бусад хотын "Хан-нара" ТББ-ын төлөөллүүд 45 хүний бүрэлдэхүүнтэй манай аймагт зочилж, Арвайхээр хотын "Их Монгол" цэцэрлэгт хүрээлэнд 1000 ширхэг, Хужирт суманд 500 ширхэг нарс тарьсан. Хэрэгжилт-100 хувь
1.3.1 5	Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажилд шаардагдах хөрөнгө санхүүг нэмэгдүүлэх, тэмцлийн ажлын явцын хяналтыг сайжруулж холбогдох стандартад нийцүүлэх	УТ	Ойн хөнөөлт шавжид нэрвэгдсэн ойн сангийн буурсан талбай /га/	5	3500	2025 онд ойн хөнөөлт шавжийн тархалтын судалгааны ажлын гүйцэтгэгчээр "Их оргил ой" ХХК шалгарч, Өвөрхангай аймагт 05 дугаар сарын 15-19-ны өдрийн хугацаанд Хархорин, Хужирт, Зүүнбаян-Улаан, Уянга, Бат-Өлзий сумдын ой бүхий газруудаар нийт 98,5 га талбайд судалгааны ажил хийсэн. Үүнээс ойн хөнөөлт шавжийн тархалт илэрсэн талбай 52.5 га, устгал тэмцлийн ажил гүйцэтгэх шаардлагатай буюу яacobсоны төөлүүрч, голомтлон тархсан талбай 42.1 га байгааг тогтоосон байна. Ойн хөнөөлт шавжийн устгал тэмцлийн ажлыг улсын төсвөөр 12,0 мянган га, орон нутгийн төсвөөр 675 га, нийт 12675 га талбайд явуулахаар төлөвлөж, 06 сарын 10-ны өдрөөс хийгдэж эхэлсэн. Ойн хөнөөлт шавжийн устгал тэмцлийн ажлыг "Аглаг ой" ХХК гүйцэтгэж 2025 онд Хархорин суманд-3675 га, Хужирт суманд-3000 га, Зүүнбаян-Улаан суманд 1500 га, Уянга суманд-1500 га, Бат-Өлзий-суманд 4000 га талбайд тус тус хийгдэж аймгийн хэмжээнд нийт 12.675 га талбайд 798,0 сая төгрөгөөр хортон устгалын ажил хийгдлээ. Хэрэгжилт-100 хувь

Зорилт 1.4 Уялдаа: АЗДҮАМХ		Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт				
1.4.1	Булаг, рашааны эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах	10.0	Хашиж хамгаалсан тоо	24	10	Аймгийн Байгаль орчны газраас хашиж хамгаалах шаардлагатай булаг, шанд, рашааны эхийг хамгаалах материал нийлүүлэх ажлыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу зохион байгуулж нийлүүлэгчээр "Их дөлгөөн хангай" ХХК-иар шалгарч 300 ширхэг шургааг хүлээн авч Сант, Богд, Баруунбаян-Улаан, Баян-Өндөр сумдаас ирсэн хүсэлтийн дагуу материалыг олгож, 10 булгийн эхийг хашиж хамгаалсан. Дээрх арга хэмжээнд аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 10,0 сая төгрөг зарцуулсан. Хэрэгжилт-100 хувь
1.4.2	Газрын доорх усны мониторингийн цооног гаргуулж, мэдээлэл дамжуулах автомат багаж суурилуулах /2цооног/	30.0	Автомат багаж суурилуулсан тоо	6	2	Өвөрхангай аймгийн Хархорин, Гучин-Ус сумдын ундны усны эх үүсвэрт газрын доорх усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, усны хяналт- шинжилгээний цооногт автомат багаж суурилуулан улсын нэгдсэн сүлжээнд холбох ажлыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчээр КРМ ХХК шалгарч тус ажлыг гүйцэтгэн www.groundwater.mn системд холбосон. Хэрэгжилт-100 хувь
1.4.3	Арвайхээр сумын ундны усны эх үүсвэрийн усны хэрэглээ ашиглалтыг хянах мониторингийн цооногийг сэргээж, өрөмдөх	9.0	Цооногийг сэргээж засварласан эсэх	-	1	Арвайхээр сумын ундны усны эх үүсвэрийн усны хэрэглээ ашиглалтыг хянах мониторингийн цооногийг сэргээж өрөмдөх ажлыг "Баянговь ус" ХХК-тай гэрээ байгуулан 2025 оны 05 дугаар сарын 15-ны

						өдөр Онги-Таац голын сав газрын захиргаа, газрын мэргэжилтнүүдийн төлөөлөл хүлээн авлаа. Тус цооног нь худгийн гүн 23.0 м, цооногийн ундарга 10 л/с, статик түвшин 1,5 м, динамик түвшин 20 м бөгөөд хяналт шинжилгээний автомат багаж суурилуулан Арвайхээр сумын ус хангамжийн эх үүсвэрийн газрын доорх усны хэлбэлзлийг хянах боломж бүрдсэн.
						Хэрэгжилт-100 хувь
1.4.4	Өвөрхангай аймгийн томоохон гол, нууруудын усны түвшин, талбай болон голдирлын өөрчлөлт, чанарын судалгааг хийх, гидрологийн катологи хэвлүүлэх	19,0	Судалгаа эсэх хийгдсэн	-	1	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Өвөрхангай аймгийн уур амьсгал, гадаргын усны горим, түүний нөөц хувьсал хэлбэлзлийн судалгаа, атлас боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр ажлын даалгаврыг боловсруулан үнийн санал авч, ус цаг уур орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн судалгааны багтай гэрээ байгуулан Өвөрхангай аймгийн уур амьсгалын тойм түүний өөрчлөлтийг олон жилийн мэдээлэлд үндэслэн зураг боловсруулах, үнэлгээ дүгнэлт өгөх, аймгийн хэмжээний томоохон гол, нууруудын чанарын судалгааг хийх /усны хими, биологи/, гадаргын усны горим, түүний нөөц хувьсал хэлбэлзлийн судалгаа хийх, дүгнэлт цаашид авах арга хэмжээг тодорхойлох, томоохон голуудын голдирлын өөрчлөлт, нууруудын дүрс зүйн үзүүлэлтийн өөрчлөлтийг сансрын зураг ашиглан зураглал гаргах /2000-2025 он хүртэл/, Хүйсийн найман нуурын бүс орчимд ургамлын нөмрөгийн судалгааг хийж, атлас хэвлүүлэх ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.
						Хэрэгжилт-100 хувь
1.4.5	Арвайхээр сумын ундны усны эх үүсвэрийн худгуудыг чанарын шинжилгээнд хамруулах	5,0	Шинжилгээнд хамруулсан эсэх	-	30	Арвайхээр сумын Бурхийн рашаан, Дэлгэрэх булаг, зөөврийн 21 ус түгээх байрны усны химийн шинжилгээг SGS лабораторид 57 үзүүлэлтээр тодорхойлуулсан.

						Шинжилгээний дүн ундны усны MNS0900:2018 стандарттай харьцуулахад давсан үзүүлэлт байхгүй чанарын шаардлага хангасан байна. Хэрэгжилт-100 хувь
	Хөв цөөрөм байгуулах, голын голдирылыг шулуутгах зураг төсөв хийлгэх, хөв цөөрмийн ашиглалтыг сайжруулах.					Баян-Өндөр сумын Харзтайн хөв цөөрмийг засварлах, Богд суманд шинээр хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсвийг боловсруулах ажлыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчээр Гидрофонтан ХХК шалгарч зураг төсөв боловсруулах ажлыг гүйцэтгэж, магадлалаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Уг арга хэмжээнд аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 40,0 сая төгрөг зарцууллаа. Хэрэгжилт-100 хувь
1.4.6		40,0	Зураг төсөв хийлгэсэн эсэх	1	2	
1.4.7	Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бүсийг тогтоож аймгийн ИТХ-аар батлуулж хууль зүй дотоод хэргийн яаманд бүртгүүлэх	1.0	Ажлын гүйцэтгэл	-	100%	Өвөрхангай аймгийн Засаг даргын 2023 оны А/417 захирамжаар "Уст цэгийн тоо бүртгэл хийх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох" ажлын хэсэг байгуулагдаж аймгийн 16 суманд 6 дугаар сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны өдрийн хугацаанд хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэж, хамгаалалтын бүсийн зураглалын ажлыг Arcgis 11.8, Qgis, Google Earth програмуудыг ашиглан боловсруулсан. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох ажлын явц, зураглал, онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд давхцалтай газруудын судалгааг гарган аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох ажлын талаар БОУАӨЯ, ХББОСЯ-наас дүгнэлт, санал зөвлөмж авч давхцалтай

						газруудад газар эзэмшигч хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдүүдийн төлөөллийг оролцуулсан нийтийн сонсгол, хэлэлцүүлгийг хийж Арвайхээр, Баруунбаян-Улаан сумдад хийсэн. Хэрэгжилт-70 хувь
Зорилт 1.5 Уялдаа: АЗДҮАМХ		Зорилт 5. Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах хүрээнд (ан амьтан, ургамал, хог хаягдал, орчны бохирдол, нөхөн сэргээлт)				
1.5.1	Зэрлэг амьтны тархац нутаг малын бэлчээртэй давхацсан бүс нутагт мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	1	Зэрлэг амьтны тархац нутаг малын бэлчээртэй давхацсан бүс нутагт Баруунбаян-Улаан суманд агнуурын бүс нутгийн ойролцоох 70 гаруй өрхийн хурга ишгэнд мялзан эсэргүүцэх вакцин, Есөнзүйл суманд 12 өрхийн бог малд мялзангийн вакцин, үхэрт цусан халдварт вакциныг тус тус хийгдсэн байна. Зэрлэг амьтны тархац нутаг малын бэлчээртэй давхацсан бүс нутагт мал амьтны гаралтай халдварт өвчин гараагүй. Хэрэгжилт-100 хувь
1.5.2	Ган, зуд, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх	5,894,200	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	18	10	Агнуурын бүс нутгийн байгаль хамгаалагчид ховор ан амьтдын тархац, байршил өсөлтөд байнгын ажиглалт судалгаа хийж, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, нутгийн иргэдтэй хамтран 2025 онд сум орон нутгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар аймгийн хэмжээнд 8 суманд 560 боодол өвс 8 тонн хужир тавьж өгч 22 удаагийн биотехникийн арга хэмжээ авч ажиллалаа. Хэрэгжилт-100 хувь
1.5.3	Идлэг шонхор шувууг соёлын зориулалттай барьсан төлбөрийн орлогын зарцуулалтад хяналт, шалгалт хийх, шонхор шувуу	-	Идлэг шонхор бариулсан сум бүрийн хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	9	10	Аймгийн Байгаль орчны газрын дотоод хяналтын нэгжээс 2025 оны 3 сард Хужирт, Хархорин, Бат-Өлзий сумдад, 5 сард Гучин-Ус, Богд, Баруунбаян-Улаан, Хужирт, Бүрд, Есөнзүйл, Баян-Өндөр, Сант сумдад, 9 дүгээр сард Тарагт, Уянга сумдад дотоод хяналт шалгалт зохион байгуулж, 2024, 2025

	хамгааллын арга хэмжээг зохион байгуулах					онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажил болон 2026 оны арга хэмжээний төлөвлөлт, байгаль орчны төсөв мэдээллийн сангийн программын ашиглалтад хяналт үнэлгээ хийж, мэргэшил арга зүйгээр хангаж зөвлөн туслах ажил зохион байгууллаа. Энэ онд ан амьтдыг хамгаалах чиглэлээр амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоор Тарагт сум Хүрэмт, Урт гэх газруудад 15 ширхэг шувууны үүр, 10 ширхэг шувууны суудал хийж байршуулсан. Идлэг шонхор шувууг соёлын зориулалтаар барих үйл ажиллагаа 2025 оны 07 дугаар сараас 11 сар хүртэл явагдаж, тус аймгийн 14 сумаас 102 ширхэг идлэг шонхор барьж сум, орон нутгийн төсөвт 2,2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүллээ. Тус газраас идлэг шонхор барих хугацаанд хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж, гэрээний биелэлтийг хангуулан ажилласан. Хэрэгжилт-100 хувь
1.5.4	Нэн ховор, ховор болон ялангуяа нүүдэллэдэг зэрлэг амьтдын тархац нутаг болон нүүдлийн замыг хамгаалах ажлыг зохион байгуулах	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	1	Нэн ховор амьтан болох ирвэс ихээр байршдаг Нарийнтээл сумын “Шаргын хадан” гэх газарт агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчидтай хамтран хөдөлгөөн мэдрэгч камерыг суурилуулж, нутгийн иргэдэд малаа ирвэсээс хамгаалах арга болон, ирвэстэй таарсан тохиолдолд авах арга хэмжээний талаарх мэдээллийг хүргэн ажиллаж байна. Хэрэгжилт-100 хувь
1.5.5	Орон нутгийн амьтан хамгаалал, судалгаа шинжилгээний чиглэлийн мэргэжлийн байгууллага, ТББ-тай хамтран ажиллах, судалгаа шинжилгээ, амьтан	-	Хамтран ажилласан ажлын тоо хэмжээ	5	3	-Аймагт агнуурын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй менежмент хариуцагчид болон нөхөрлөлүүдтэй 2 удаагийн хурал зохион байгуулж, 2026 оны ангийн саналыг боловсруулан Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яаманд аймгийн Засаг даргын албан тоотоор хүргүүлсэн.

	асрах, хамгаалах чиглэлээр хамтран, дэмжиж ажиллах					-Баруунбаян-Улаан сумын Бага богд, Өшгөгийн нурууны менежмент хариуцагч аж ахуй нэгж "Атон аммон" ХХК-тай хамтран 80 боодол өвс, 600 кг хужрыг зэрлэг амьтдад тавьж өгч 3 удаагийн биотехникийн арга хэмжээ авсан. Хэрэгжилт-100 хувь
1.5.6	БНХМ-ийн нөхөрлөлүүдийн мэдээлэл болон кадастрыг байгаль орчны мэдээллийн сан /www.eis.mn/ болон газар зохион байгуулалт, геофизи зураг зүйн газрын мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулах	-	Гүйцэтгэлийн хувь	-	100%	БОУАӨЯамнаас сургалт зохон байгуулагдаж хийгдэх байсан боловч энэ онд хийгдээгүй. Хэрэгжилтийг тооцох боломжгүй
1.5.7	Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 -т заасан урамшуулал олгох шалгуур үзүүлэлт, урамшууллын хэмжээ, түүнийг олгох, санхүүжүүлэх, зарцуулах журмыг баталж мөрдүүлэх;	-	Ажлын гүйцэтгэл	Журмыг батлуулсан байна.	100%	Хийгдээгүй. Хэрэгжилт-0
1.5.8	Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1. энэ хуулийн 8.7.2-т заасан аргачлалын дагуу энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг батлуулж мөрдүүлэх;	-	Ажлын гүйцэтгэл	Журмыг батлуулсан байна.	100%	-Аймгийн хэмжээнд 15 сум хог хаягдлын үйлчилгээний хураамжийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтоож, нэгж тарифын хэмжээг батлан мөрдлөг болгон ажиллаж байна. 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хог хаягдлын үйлчилгээний хураамж 581,1 сая төгрөгийг бүрдүүлж, төлөвлөлтийн 78.5 хувийг аймаг, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. -Батлагдсан тарифын дагуу орон нутгийн төсөвт хог хаягдлын үйлчилгээний хураамжаас орсон орлогын тодорхой хувийг энгийн хог хаягдлыг булшлах зардал болон хог хаягдлын чиглэлд зарцуулах үйл ажиллагааны зардлыг төсөвт суулгаж, сумдууд төвлөрсөн хогийн цэгийн талбайн

						хэмжээг багасгах, дарж булшлах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Хэрэгжилт-90 хувь
1.5.9	Хог хаягдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5-д "Энэ хуулийн 8.1.14-т заасан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүрэгтэй" гэж заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайд нарын хамтарсан А429/257 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах	-	Хэрэгжилтийн хувь		100%	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайд нарын хамтарсан А429/257 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд "Жем Хужирт" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд 0.33 л хэмжээтэй шил 200 төгрөгөөр 233,100 ширхэг, 0.6 л хэмжээтэй шил 300 төгрөгөөр 50,975 ширхгийг худалдан авч хог хаягдлыг ангилан ялгаж орчны бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлээд байна. Мөн орон нутагт албан ёсны гэрээт борлуулагчаар ажиллаж байгаа ААН-үүдийн төлөөллүүдтэй уулзалт хийж дахивар авах цэгүүдийн үйл ажиллагааг дэмжих, хуванцар сав, шилийг эргүүлэн цуглуулах талаар санал солилцсон. Хэрэгжилт-70 хувь
1.5.1 0	БОУАӨСайдын 2024.09.13-ны өдрийн 07 тоот албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах	-	Биелэлтийн хувь	2023.02.28-ны 02, 03, 04 албан даалгавар		Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын "Шатахуун түгээх станцаас үүдэлтэй хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай" 07 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Аймгийн хэмжээнд 83 шатахуун түгээх станц үйл ажиллагаа явуулж байгаагаас 2025 онд 15 аж ахуйн нэгж байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулаад байна. Эдгээр аж ахуйн нэгжийн төлөвлөгөөнд эко 00 байгуулах, нийгмийн хариуцлагын хүрээнд мод тарих, хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, хөрсний нянгийн болон хүнд металлын бохирдлын түвшинг тогтоох шинжилгээг хийлгэх талаар арга хэмжээг тусган баталсан.

						Арвайхээр сумын 12 ШТС, Тарагт сумын 2 ШТС, Хархорин, Бат-Өлзий, Уянга, Хужирт сумдын аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч 30 газарт "Нүхэн жорлон, угаадасны нүх Техникийн шаардлага MNS 5924.2015 улсын стандартын шаардлага хангасан эко жорлон байгуулах, стандартын шаардлага хангахгүй, хөрс бохирдуулагч нүхэн жорлонг татан буулгаж, халдваргүйжүүлж, орчны хөрсийг нөхөн сэргээх талаар хууль эрх зүйн заавар зөвлөгөө өгч, улсын байцаагчийн 22 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.
						Хэрэгжилт-100 хувь
1.5.1 1	Орон нутгийн хэмжээнд нүхэн жорлонгийн тооллого хийж, /ой ба усан сан, тусгай хамгаалалттай газар/, нүхэн жорлонг халах төлөвлөгөөг баталж, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх	-	Нэмэгдсэн ариун цэврийн байгууламжийн тоо	2023 оны тооллого		Аймгийн хэмжээнд нүхэн жорлонгийн тооллого судалгааны ажлыг зохион байгуулж, нүхэн жорлонг халах төлөвлөгөөг судалгааны хамт Байгаль орчны газрын даргын 2025 оны 35 дугаар албан бичгээр БОУАӨЯ-нд хүргүүлсэн. Тус тооллого судалгаагаар төв, суурин газрын гэр хорооллын айл өрхийн 13473, зуслангийн 1043, малчин өрхийн 2603, төрийн байгууллагын 42, зочид буудал зоогийн газрын 10, худалдаа үйлчилгээ, төв захын 24, шатахуун түгээх станцын 40 нүхэн жорлон тоологдсон ба үүнээс 2025 онд 240 нүхэн жорлонг дарж булах төлөвлөгөөний дагуу Хайрхандулаан сум 42, Гучин-Ус сум 3, Зүүнбаян-Улаан сум 3, Төгрөг сум 16, Бат-Өлзий сум 39, Тарагт сум 2, Хархорин сум 73, Хужирт сум 15, Бүрд сум 5, Арвайхээр сум 33 буюу аймгийн хэмжээнд нийт 231 нүхэн жорлон дарж булсан бөгөөд шинээр 75 эко ариун цэврийн байгууламж баригдсан.
						Хэрэгжилт-100 хувь
1.5.1 2	Хууль бус ашигт малтмал олборлолтыг таслан зогсоох	-	Хяналт шалгалтын тоо	6	5	Тус аймгийн Хайрхандулаан сумын нутагт хууль бусаар ашигт малтмал олборлосон иргэдийг экологийн Цагдаагийн албатай

	хяналт эрчимжүүлэх	шалгалтыг				хамтарч 40 удаа хяналт шалгалт зохион байгуулж шалгалтаар илэрсэн 8 гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож ажилласан. Хэрэгжилт-100 хувь
1.5.1 3	Эвдэрсэн газрын тооллогын мэдээг байгаль орчны мэдээллийн санд оруулах	-	Гүйцэтгэлийн хувь	2023 онд улсын хэмжээнд эвдэрсэн газрын тооллого хийгдсэн.	100%	2023 онд улсын хэмжээнд эвдэрсэн газрын тооллого хийгдсэн ба түүнээс хойш шинээр эвдрэлд орсон талбай байхгүй болно. Хэрэгжилт-100 хувь
1.5.1 4	Эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх	-	Нөхөн сэргээлт хийсэн талбай	Техникийн нөхөн сэргээлт 36.7 га, биологийн нөхөн сэргээлт 12.27 га талбайд	20 га	Аймгийн хэмжээнд ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд 2025 онд техник болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөгөөний дагуу болон түүнээс давуулан хэрэгжүүлсэн байна. Үүнд: "Өгөөмөр-Өргөө" ХХК 2 га техникийн, 2 га биологийн, "Импери Майнинг" ХХК 10 га-д техникийн, 5 га-д биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөгдсөнөөс 13.1 га техникийн, 7.1 га биологийн нөхөн сэргээлт хийж давуулан гүйцэтгэсэн байна. "Эм Эс Бэл Майнинг" ХХК төлөвлөгөөний дагуу 2 га-д техникийн нөхөн сэргээлт, "Баярсгоулд" ХХК 5 га талбайд биологийн, "Буд-Ундром" ХХК 16.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт тус тус хийсэн байна. Аймгийн хэмжээнд 2025 онд техникийн нөхөн сэргээлт 33.9 га, биологийн нөхөн сэргээлт 14.1 га, нийт: 48 га-д нөхөн сэргээлт хийгдсэн байна. Аймгийн хэмжээнд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд дүйцүүлэн хамгаалал, экологийн тэнцвэрийг хангах зорилтын хүрээнд Онги голын татмын

						экосистемийг хамгаалах, ойжуулалтын бүсийг нэмэгдүүлэх ажлуудыг төлөвлөн зохион байгууллаа. Уг үйл ажиллагаанд "Өгөөмөр Өргөө" ХХК, "Аум Алт" ХК, "Баянтээг" ХК, "Баярсгоулд" ХХК, "Эм Эс Бэл Майнинг" ХХК болон "Импери Майнинг" ХХК-иуд хамтран оролцсон бөгөөд Онги голын дагуу нийт 40 га талбайд хашаажуулалтын ажлыг хийж, 2026 онд онд мод бут тарих ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.
						Хэрэгжилт-100 хувь
	Зорилт 1.6 Уялдаа: АЗДҮАМХ	Зорилт 6 Байгаль орчны хяналт, шалгалтын хүрээнд:				
1.6.1	Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 02 дугаар тогтоолын дагуу 38 обектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж үр дүнг тооцох,		Шалгалтад хамрагдах обектийн тоо	38	100	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны салбарын хяналтын газраас баталсан 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 7 удирдамжийн хүрээнд зохион байгуулж 100 зөрчлийн гомдол мэдээллийг шалгаж 81 зөрчилд 53.2 сая төгрөгийн торгууль оногдуулж, байгальд учирсан хохирлын 73.5 төгрөг нөхөн төлүүлж шийдвэрлэлээ. Гэмт хэргийн шинжтэй 6 үйлдлийг цагдаагийн байгууллагад, харьяаллын дагуу, бусад байгууллагад 10 зөрчлийг шилжүүлж, 1 зөрчлийг хүлээн авахаас татгалзаж, 2 зөрчлийг шалгаж байна. Цаг үеийн шинж чанартай орон нутгийн онцлогт тохирсон хяналт шалгалтуудыг тухай бүр зохион байгуулж ажилласан. Тухайлбал: Хайрхандулаан сумын 4 дүгээр багийн нутаг, Зангатын хоолой гэх газарт 2024 оны 12 дугаар сараас эхлэн аймгийн Цагдаагийн газар, Хайрхандулаан сумын ЗДТГ-тай хамтран хууль бусаар ашигт малтмал эрэх, хайх, олборлох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт 40

					удаа зохион байгуулж, гэмт хэргийн шинжтэй 7 үйлдлийг цагдаагийн газар мөрдөн шалгаж байна. 2025 оны 2-4 дүгээр саруудад Арвайхээр сумын дулаан үйлдвэрлэгч аж ахуй нэгж байгууллагуудад, 2 дугаар сард мод бэлтгэлийн үйл ажиллагаанд, 5-6 дугаар сард хог хаягдал орчны бохирдол, рашаан сувиллуудын ус ашиглалтын байдалд, 7-10 дугаар саруудад байгалийн дагалт баялаг түүж бэлтгэх, хууль бус ан агнуур, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллагуудын нөхөн сэргээлт, ус ашиглалтын байдалд тус тус хяналт шалгалтуудыг тухай бүр зохион байгуулж ажилласан. Ой хээрийн түймэр гарах эрсдэл бүхий 3-6, 9-10 дугаар саруудад ой бүхий сумдын Засаг даргын Тамгын газар, сум дундын Ойн анги, аймгийн Онцгой байдлын газартай хамтран ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажил, ой бүхий газарт хаваржиж байгаа айл өрхүүдтэй хариуцлагын гэрээ байгуулж ажилласны үр дүнд ой хээрийн түймэр гараагүй. Хяналт шалгалтын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 273 заалт бүхий 53 улсын байцаагчийн албан шаардлага, 17 заалт бүхий улсын байцаагчийн 4 зөвлөмжийг холбогдох иргэн байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллалаа. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 20,0 сая төгрөг төлөвлөж, албан хаагчдын томилолт, шатахуун, урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээнд зарцууллаа.
--	--	--	--	--	--

						Хэрэгжилт-100 хувь
1.6.2						Энэ онд 01/06 "Энгийн болон аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах байдалд" урьдчилан сэргийлэх, 01/09 "Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдэд" урьдчилан сэргийлэх, 01/05 "Ой, ойн дагалт баялаг, амьтан, байгалийн ургамлын чиглэлээр" урьдчилан сэргийлэх, 01/07 "Ус рашаан ашиглалтын болон усан сан бүхий газар, хүн амын унд ахуйн усны эх үүсвэрийн байдалд" урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.
	Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 02 дугаар тогтоол, БОУАӨЯ-ны салбарын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжуудын дагуу цаг үеийн шинж чанартай, орон нутгийн онцлогд тохирсон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтуудыг төлөвлөж зохион байгуулж үр дүнг тооцох,		Хяналт шалгалтад хамрагдсан объект, иргэн, илрүүлсэн, арилгасан зөрчил, торгууль, нөхөн төлбөрийн тоо, хэмжээ	86	-	Хяналт шалгалтаар: 1.Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар Арвайхээр суманд дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа 8 аж ахуй нэгж байгууллагын 13 дулаан үйлдвэрлэгч объектод 2025.02.17-оос 3 сарын 12 хүртэл хугацаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлын арилгуулахаар шалгалтад хамрагдсан 8 аж ахуй нэгж байгууллагуудад 57 заалт бүхий хугацаатай улсын байцаагчийн 8 албан шаардлага хүргүүлсэн. "Арвайн илч" ХХК, "Зэвсэгт хүчний 256 дугаар анги", "Өв-Илч" ХХК, "Хангамж орд" ХХК, "Бага Хайлантай" ХХК, "Газрын улаач" ХХК-уудад зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу тус бүр 3.000.000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн. 2.Энгийн болон аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах устгах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Чинмэнд эмнэлэг, Ариунсанаа эмнэлэг, Өрхийн эмнэлгүүд, Бат-

					Өлзий Хужирт, Есөнзүйл Баян-Өндөр, Сант Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Богд, Тарагт сумдын эрүүл мэндийн төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг "Авто замын засвар арчлалтын нэгтгэл төрийн өмчит хувьцаат компанийн харьяа Хархорин сум дахь салбарт зориулалтын бус цэгт үүсэн үүсмэл хогийн цэгт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж ажиллалаа. Илэрсэн зөрчил дутагдлын арилгуулахаар шалгалтад хамрагдсан 14 аж ахуй нэгж байгууллагуудад 60 заалт бүхий хугацаатай улсын байцаагчийн 14 албан шаардлага хүргүүллээ. 3. Ан агнах, барих худалдаалах, худалдан авах, тээвэрлэх байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 01/05 дугаартай удирдамжийн дагуу Аймгийн ИТХ-ын 2024 оны "Бэлтгэх модны дээд хязгаар тогтоох тухай" 02/05 дугаар тогтоолын дагуу Бат-Өлзий сумын нутаг, улсын тусгай хамгаалалттай газар нутагт явагдаж байгаа ойн цэвэрлэгээ, мод бэлтгэлийн ажилд Сум дундын Ойн анги, Бат-Өлзий сумын ЗДТГ-тай хамтарч хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтаар хаврын цаг агаарын хуурайшилт эхэлж байгаатай холбогдуулан ойн түймрээс урьдчилан сэргийлэх, багаж хэрэгсэл, техникийн бэлэн байдал, хөдөлмөрийн аюулгүй байдлаа хангаж байгаа эсэхэд мэргэжил арга зүйгээр хангаж, заавар зөвлөгөө өгч зарим зөрчил дутагдлыг газар дээр арилгуулж ажиллалаа. Мөн Бат-Өлзий суманд модоор гэрийн мод, тавилга хийдэг иргэний төлөөлөлтэй уулзаж тулгамдаж байгаа асуудал, цаашид шийдвэрлэх асуудлын талаар санал солилцлоо. Гэрээний дагуу ойд ойн цэвэрлэгээ явуулахдаа түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг
--	--	--	--	--	--

					тогтоосон норм, нормативын дагуу бүрдүүлээгүй 1 аж ахуй нэгж байгууллагад Зөрчлийн тухай хуулийн 7.9.9-д заасны дагуу 1.500.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авлаа. Ойн тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй 5 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 7.9.10-т заасны дагуу тус бүр 50.000 төгрөгийн торгууль оногдууллаа. Нийт 1 аж ахуй нэгж байгууллага 5 иргэнд 1.750.000 төгрөгийн торгууль оногдуулж, ойд учирсан хохирлын 1.005.600 төгрөгийг нөхөн төлүүллээ. Гэмт хэргийн шинжтэй 9 үйлдлийг цагдаагийн байгууллагад шилжүүлэх саналтайгаар Прокурорт хүргүүлж шийдвэрлэлээ. Хууль бусаар ангын гаралтай мах арьс түүхий эд худалдаалсан тээвэрлэсэн 14 зөрчлийн гомдол мэдээллийг хүлээн авч 8 зөрчилд 2.400.000 төгрөгийн торгууль оногдуулж, ан амьтны санд учирсан хохирлын 7.014.000 төгрөгийг нөхөн төлүүлж, зөрчлийн эд мөрийн баримтаар хураан авсан 73 ширхэг амьтны махыг зохих журмын дагуу шийдвэрлэж ажиллалаа. 4. Ус рашаан ашиглалт болон усан сан бүхий газар, хүн амын ундны усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2025 оны 05 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Хужирт сумын нутагт дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 6 рашаан сувиллын газрууд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулах талаар 44 заалт бүхий 6 албан шаардлага хүргүүлж биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. "Те Ба Сэ" ХХК-ийн Сэмжид рашаан сувилал, "Элма Хужирт" ХХК, "Ананд Хужирт" ХХК, "АЖУДС" ХХК-ийн Газарчин сувилал, "Хужирт
--	--	--	--	--	---

						Тур" ХХК-ийн Хан Хужирт сувиллууд нь 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ажилласан зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж Зөрчлийн тухай хуулийн 7.1.2-т заасны дагуу тус бүр 500 нэгжээр торгох шийтгэл оногдуулж материалыг хянуулахаар прокурорт хүргүүлсэн. Хэрэгжилт-100 хувь
1.6.3	Иргэн, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах,		Ирсэн өргөдөл гомдол хүсэлтийн тоо	-	Ирсэн өргөдөл гомдол хүсэлт бүрийн дагуу хяналт шалгалт хийгдсэн байна.	-Хайрхандулаан суманд хууль бусаар алт олборлож байна гэх гомдол мэдээллийн дагуу 40 удаагийн хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулж, гэмт хэргийн шинжтэй 7 үйлдлийг ирлүүлэн, цагдаагийн байгууллага мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. -Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдэд хяналт шалгалт хийж өгнө үү гэх Тарагт сумын Засаг даргаас ирсэн гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт, БОУАӨЯамны 117 тусгай дугаарт ирсэн Бат-Өлзий суманд хууль бусаар мод бэлтгэж байна гэх гомдол мэдээллийг хүлээн авч удирдамж батлуулан хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулж, иргэнд хариуг мэдэгдсэн. Хэрэгжилт-100 хувь
1.6.4	БОГ-ын байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч, сумдын ЗДТГ-ын байгаль орчны хяналтын улсын байцаагч нарыг чадавхжуулах сургалтад цахим болон танхимаар хамрагдсан байна.		Зохион байгуулсан, оролцсон сургалт, хамрагдсан улсын байцаагч нарын тоогоор		Бүх улсын байцаагч нар 2-оос доошгүй сургалтад хамрагдсан байна.	-БОУАӨЯ-ны салбарын хяналтын газраас баталсан 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжуудыг 19 сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт цахимаар танилцуулж үүрэг, чиглэл өгч санал солилцлоо. -Сумдын БОХУБайцаагч нарыг чадавхжуулах, цаг үеийн мэдээ мэдээллээр хангах сургалт, уулзалт семинарыг 3 удаа зохион байгуулсан. Хэрэгжилт-100 хувь

							Хэсгийн дундаж үнэлгээ	92,4 хувь
ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ								
Зорилт 2.1		Байгууллагын дотоод хяналт, архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг хэрэгжүүлэх						
2.1.1	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулах;	-	Дотоод хяналтын чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ, чанар, үр дүн	3	Дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	-Байгууллагын дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг гаргаж газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Дотоод хяналтын нэгж нь газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу 2025 оны 3,5,9,12 дугаар саруудад хуваарийн дагуу бүх сумдад ажиллаж, Бат-Өлзий суман дахь Сум дундын Ойн анги, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын үйл ажиллагаа, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон журмын хэрэгжилтэд дотоод хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Сумдын удирдлагууд болон холбогдох албан хаагчдад Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Засгийн Газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ыг талаар сургалт зохион байгуулж, сумдад 2025 онд хийгдсэн ажил болон 2026 оны арга хэмжээний төлөвлөлт, байгаль орчны төсөв мэдээллийн сангийн программын ашиглалтад хяналт үнэлгээ хийж, мэргэшил арга зүйгээр хангаж зөвлөн туслах ажил зохион байгууллаа. Хэрэгжилт-100 хувь		
2.1.2	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилах;	-	-Авлига сонирхлын гарсан эсэх	-	-	-Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг боловсруулж, газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган тайланг хагас жилийн байдлаар гаргаж ЗДТГ-ын		

					Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Хууль эрх зүйн хэлтэст албан тоотоор хүргүүлсэн. -Төлөвлөгөө болон сурталчилгаа материалуудыг байгууллагын nature.ov.gov.mn байгууллагын албан ёсны вэйб сайтад байршуулж мэдээ мэдээллийг шинэчлэн ил тод байдлыг ханган ажиллалаа. -ХАСХОМ, ХАСУМ-ийг холбогдох албан хаагчдаас хуулийн хугацаанд гаргуулж, холбогдох судалгаа тайланг цаг тухайд нь гаргаж Хууль зүйн хэлтэст хүргүүлж ажиллалаа. Хэрэгжилт-100 хувь
2.1.3	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилийг хангах;	-	Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгээр	2024 оны төлөвлөгөө 93,7 хувьтай хэрэгжсэн.	Төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг тооцож ажилласан байх;	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Засаг даргаар баталгаажуулж хэрэгжилтийг хангах хүрээнд албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст албан тоотоор хүргүүлээ. Хэрэгжилт-100 хувь
2.1.4	Тухайн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж, түүний мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж биелэлтийг хангах;	-	Чанар, үр дүн, хэрэгжилтийн хугацаа	Тогтоосон хугацаанд тайлагнасан.	Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу тайланг нэгтгэж биелэлт, үр дүнг тооцон холбогдох газарт тайлагнасан байх;	-Байгууллагын 2024 оны хяналт, шинжилгээ-үнэлгээний тайланг ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу нэгтгэн хяналт үнэлгээ хийж, тогтоосон хугацаанд ЗДТГ-т хүргүүлсэн. -Аймгийн ЗДТГ-аас 2024 оны тайланд хийсэн хяналт шинжилгээ-үнэлгээгээр 88,2 хувьтай үнэлэгдэж, үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын 2025 оны гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг боловсруулж, газрын даргаар батлуулан мэргэжилтнүүдэд танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэрэгжилт-100 хувь

						-Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор "Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан уг журмыг албан хаагчдад танилцуулах сургалтыг 2025 оны 2 дугаар сард зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. -Байгууллагын 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж даргаар батлууллаа. Мөн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Тамга тэмдэг түших болон хэвлэмэл хуудас хариуцах ажилтныг томилсон. Архивын тухай хууль, тогтоомж болон байгууллагын архивын дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. -Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор "Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан уг журмыг албан хаагчдад танилцуулах сургалтыг 2025 оны 2 дугаар сард зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. -Байгууллагын 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж даргаар батлууллаа. Мөн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Тамга тэмдэг түших болон хэвлэмэл хуудас хариуцах ажилтныг томилсон. -Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн удирдамж"-ийн дагуу байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө
2.1.5	Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;	-	Архив, албан хэргийг холбогдох хууль, журам, заавар, стандартын дагуу хөтөлсөн байна.	-	-Албан хаагчдад сургалт зохион байгуулах -Заавар стандартыг мөрдөж ажиллах	-Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор "Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан уг журмыг албан хаагчдад танилцуулах сургалтыг 2025 оны 2 дугаар сард зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. -Байгууллагын 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж даргаар батлууллаа. Мөн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Тамга тэмдэг түших болон хэвлэмэл хуудас хариуцах ажилтныг томилсон. Архивын тухай хууль, тогтоомж болон байгууллагын архивын дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. -Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор "Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан уг журмыг албан хаагчдад танилцуулах сургалтыг 2025 оны 2 дугаар сард зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. -Байгууллагын 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж даргаар батлууллаа. Мөн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Тамга тэмдэг түших болон хэвлэмэл хуудас хариуцах ажилтныг томилсон. -Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн удирдамж"-ийн дагуу байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө

гарган тухайн ажлын хүрээнд байгууллагын БНШК-ын бүрэлдэхүүн, дүрмийг газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/10 дугаар, Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улмын үзлэгт бэлтгэх ажлын талаар авах хэмжээ А/29 дугаар тушаалуудыг гаргасан. Улсын үзлэгийн дүгнэх аргачлалын дагуу архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангаж 6 хавтас материалыг бэлтгэн биелэлтийг гарган дүгнүүлсэн. Үүнд Архивын улсын үзлэг, Данс, архивын бүртгэл, сургалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт бүхий хавтаснуудыг 2 жилийн байдлаар бэлтгэсэн. Улсын үзлэгийн зохион байгуулалтын талаар албан хаагчдад сургалт орж архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 20 асуулт бүхий тестийн шалгалтыг авсан. Байгууллагын архивын төрийн архивд хүлээлгэн өгсөн 3 удаагийн бүртгэл, архивд хадгалагдаж байгаа түр, 70 жил, байнга хадгалах баримтын бүртгэлийг шинэчилэн гаргаж хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэ журмын дагуу шинээр хийж, баримтыг хадгалах шүүгээнд заагуур хийж, архивын лавлагаа, баримт бичиг хүлээлцэх, хэвлэмэл хуудасны бүртгэл зэргийг шинэчилэн гаргасан. Аймгаас томилогдсон улсын үзлэгийн шалгалтад шалгуулж 3 үзүүлэлтийн нийлбэр дүнгээр 95 хувьтай дүгнэгдсэн.

Хэрэгжилт-100 хувь

100 хувь

Хэсгийн дундаж үнэлгээ

ГУРАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

Зорилт 3.1

Байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ил тод, чирэгдэлгүй, түргэн шуурхай, хүртээмжтэй болгох

3.1.1	Иргэдээс ирсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх;	-	Ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, мэдээ тайланг холбогдох байгууллагад тайлагнасан байдал	32	-Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэж эзэнжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах -Өргөдөл гомдлын мэдээг холбогдох дээд байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлсэн байх	-2025 оны жилийн эцсийн байдлаар газрын хэмжээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 82 өргөдөл, гомдол ирснийг хүлээн авч бүртгэн холбогдох албан тушаалтанд газрын даргын цохолтоор хүлээлгэн өгч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн -Өргөдөл гомдлын мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны удирдлагын газарт улирал бүр гарган хүргүүлж, байгууллагын цахим сайтад өргөдөл гомдлын талаарх мэдээ мэдээллийг байршуулж ил тод байдлыг ханган ажиллаж байна. Хэрэгжилт-100 хувь
3.1.2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ ус, рашаан ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, ой, ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргах.	-	Гаргасан үнэлгээ, дүгнэлт, зөвшөөрлийг хууль тогтоомжийн хүрээнд гаргасан байх	73	Иргэдэд үзүүлж буй үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд чирэгдэлгүй, хурдан шуурхай хүргэсэн байх.	-Энэ онд иргэн аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ 31, ус, рашаан ашиглах 16 дүгнэлт, 43 худгийн зөвшөөрөл олгосон байна. Ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээ 45, ойд учруулсан экологи эдийн засгийн үнэлгээ 27, тус тус гаргаж иргэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг шийдвэрлэсэн байна. Хэрэгжилт-100 хувь
Хэсгийн дундаж үнэлгээ						100 хувь
БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД НЭМЭЛТЭЭР ТУСГАХ ЗАХИАЛГАТ АРГА ХЭМЖЭЭ						
1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, хуулиар хүлээсэн үүргээ ёс зүй, хариуцлагатайгаар бүрэн биелүүлж ажиллана.						
1.1.1	Хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	-Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлсэн байдал -Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны	2025 оны хяналт шинжилгээ, үнэлгээн ий дүн	2025 оны хамаарал бүхий зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.	Байгаль орчны салбарын бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт, хөтөлбөрүүдийн салбарт хамаарах зорилт арга хэмжээний биелэлтийг тухай бүр гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлж тайлагнасан. ЗДТГ-ын ХШҮХэлтсээс ирүүлсэн зөвлөмжийн дагуу байгууллагын 2025 оны гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө

			хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал -Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого" дунд			боловсруулж газрын даргаар батлуулан мэргэжилтнүүдийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллалаа.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг улирал бүр гаргаж холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.
			хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал -Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлсэн байдал -Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал -Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдал -Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдал			Хэрэгжилт-100 хувь
1.1.2	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн хэмжээнд мод тарих үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх	-	-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	Аймгийн хэмжээнд мод тарьж, арчилж, ургуулах ажилд идэвхтэй оролцож, мод тарих үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэд, олон	-Мод тарих өдрүүдийн хүрээнд Богд сумын ЗДТГ-тай хамтран "Ногоон байгууламжид мод тарихад анхаарах асуудал, арчилгаа, тайралт, таналт, хэлбэржүүлэлт, ногоон байгууламжийн соёл" сэдэвт үзүүлэх сургалтыг төрийн албан хаагчид болон мод тарих хүсэл сонирхол бүхий иргэдэд зохион байгуулсан. -Хавар, намрын мод тарих өдрүүдийн хүрээнд Арвайхээр суманд үйл ажиллагаа

					нийтийг оролцуулан мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажилласан байна.	явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын ногоон байгууламж хариуцсан албан хаагчид болон Зэвсэгт хүчний 256-р ангийн хугацаат цэргийн албан хаагчдад "Ногоон байгууламжийн арчилгаа хамгаалалт, жимсний болон гоёлын мод сөөг тарьж ургуулахад анхаарах асуудал" сэдэвт сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 500 иргэн, 30 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Тус газар нь өмнөх жилүүдэд тарьсан мод бутыг арчлах, услах ажлыг "Тарьсан модоо эргэе, арчилъя усалъя" уриан дор зохион байгуулсан.
						Хэрэгжилт-100 хувь
1.1.3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ажлын үе шатны хяналтыг сайжруулан, ил тод байдлыг бүрэн хангаж, "шилэн данс"-ны мэдээллийг тогтмол шинэчлэх, худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд дуусгах	-	-Худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд дуусгасан байдал болон мэдээллийг тухай бүр шинэчилсэн эсэх -Гомдол гаргаагүй байх	-	Шилэн дансны тухай хууль болон холбогдох журамд заасан мэдээ, мэдээллийг тухай бүр нэг бүрчлэн шинэчилж хэвшсэн байна. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөн ажилласан байна.	2025 онд тус газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар шалгаруулах 3 тендер, шууд худалдан авалт хийх 5 ажил төлөвлөж 4 тендер зарлаж шалгарсан ААН-тэй гэрээ байгуулах мэдэгдэл олгоод байна. Мөн тухайн худалдан авалттай холбоотой мэдээллийг заасан хугацаанд шилэн дансанд байршуулж ажилласан. Хэрэгжилт-100 хувь
1.1.4	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон төрийн захиргааны төв байгууллагуудад асуудал тавихдаа аймгийн удирдлагад танилцуулж,	-	-Хуулиар олгосон эрхийн хүрээний асуудлаар хандсан эсэх -Холбогдох дүрэм, журмыг зөрчөөгүй байх	-	Хууль тогтоомжийн хүрээнд ажилласан байна.	Албан тоотоор асуудал тавиагүй.

	зохих журмын дагуу хүргүүлдэг байх					
1.1.5	Дээд шатны байгууллагууд болон аймгийн Засаг даргаас өгсөн хугацаатай үүрэг даалгавар, тайлан мэдээ, албан бичгийн хариуг хугацаанд нь ирүүлэх, тэдгээрийг албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, баримт бичгийн стандартын дагуу боловсруулахад онцгойлон анхаарах	-	-Тухай бүр хугацаанд нь ирүүлсэн байдал -Албан бичгийн боловсруулалтад баримт бичгийн стандартыг мөрдөж ажилласан байдал	-	Тайлан мэдээ, албан бичгийн төслийг нэг бүрчлэн хянаж, боловсруулалтын чанарыг сайжруулсан байна.	-Дээд шатны байгууллагууд болон аймгийн Засаг даргаас өгсөн хугацаатай үүрэг даалгавар, тайлан мэдээ, хугацаатай албан бичгийн хариуг цаг тухайд нь биелүүлж ажиллалаа. -Байгууллагаас гарч буй албан бичгийн боловсруулалтад баримт бичгийн стандартыг мөрдөж, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор "Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан уг журмыг албан хаагчдад танилцуулах дотоод сургалтыг 2025 оны 2 дугаар сард зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Хэрэгжилт-100 хувь
1.1.6	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааг 2 дахин бууруулж, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу иргэнээс зөвшөөрөл авах	-	-Шийдвэрлэлтийн байдал, дундаж хугацаа -Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь нэгтгэн ирүүлсэн байдал -Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төвийн 1111, аймгийн 7032-1111 дугаарт ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал	-	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд ахиц гарсан байна.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь нэгтгэн дүн мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлсэн -Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төвийн 1111 утаснаас 1 гомдол мэдээлэл, аймгийн 7032-1111 дугаарт 2 өргөдөл гомдол ирсэнийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж хуулийн хугацаанд шийдвэрлэж аймгийн хэлтэс албадын шуурхай хуралдаанд шийдвэрлэлтийн талаар мэдээлэл хийж, иргэнд хариуг хүргүүлж ажилласан. Хэрэгжилт-100 хувь
1.1.7	Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд гадаад улсын адил түвшний, эсхүл олон улсын байгууллагатай гэрээ байгуулах тохиолдолд	-	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 57 дугаар тогтоолоор батлагдсан	-	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд мөрдөж	Гэрээ байгуулагдаагүй.

	аймгийн Засаг даргын Тамгын газарт мэдэгдэж, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан байх		"Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам"-ын хэрэгжилтийг хангаж ажилласан байдал		ажилласан байна.	
1.1.8	Байгууллагын удирдлага албан томилолтоор явах болон 14 хоног тутам хуралддаг шуурхай хуралдаанаас чөлөө авахдаа аймгийн Засаг даргаас (түүний эзгүйд Засаг даргын орлогчоос) зөвшөөрөл авах	-	-Зөвшөөрлийн тоо -Зөвшөөрөлгүй явсан тохиолдлын тоо -Шуурхай хуралдааны ирц	-	Аймгийн Засаг даргад мэдэгдэж, зөвшөөрөл авч хэвшсэн байна.	Байгууллагын удирдлага албан томилолтоор явахдаа аймгийн Засаг даргад мэдэгдэж, зөвшөөрөл авч томилолтоор ажиллаж байна. Хэрэгжилт-100 хувь
1.1.9	Аймгийн Засаг даргын зөвлөлийн болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх асуудлуудыг төлөвлөгөөний дагуу тухай бүр шаардлагатай мэдээ, тайлан, статистик үзүүлэлтийн хамт бэлтгэж, хуралдаанаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах	-	-Шийдвэрлэгдсэн асуудлын тоо, чанар -Үүрэг даалгаварын биелэлтийн хувь	-	Төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажилласан байна.	Оны эхэнд аймгийн Засаг дарга болон ИТХ-ын зөвлөлөөр хэлэлцүүлэх асуудлын саналуудыг холбогдох газруудад хүргүүлж, Аймгийн Засаг даргын зөвлөлийн болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх асуудлуудыг төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг ханган оруулж, хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажилласан. Хэрэгжилт-100 хувь
1.1.10	Төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх	-	-Хэрэгжилтийн хувь	-	100.0	Тус газрын албан бичгийг дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр гаргах ажлын хүрээнд албан хаагчдаас монгол бичгээр төслийг хүлээн авч шаардлагатай албан бичгийг хэвлэмэл хуудсанд буулган хөтөлж байна. Үндэсний бичгийг сайжруулах тал дээр анхаарч хөрвүүлэх программ хангамжийг давхар ашиглан ажиллаж байна. Хэрэгжилт-85
Зорилт 1.2.Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, иргэн захиргааны байгууллагатай чөлөөтэй харилцах боломжийг бүрдүүлж ажиллана.						
1.2.1	Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж,		-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	-	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг	Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор https://nature.ov.gov.mn , албан ёсны вэйб

	төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас www.gov.mn , shilen.gov.mn сайтад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нээлттэй байхаар заасан 68 төрлийн мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулж, улирал тутам үнэлүүлэх		-Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал - shilen.gov.mn сайтын үнэлгээ		хангаж ажилласан байна.	сайтыг ажиллуулж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нээлттэй байхаар заасан 68 төрлийн мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудсанд олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр байршуулж, ил тод байдлын самбарыг шинэчилж, мэдээ мэдээллийг тухай бүр шинэчилж байна. Газрын даргын 2025 оны 04 сарын 01-ний өдрийн 6/15 тушаалаар тус газарт Олон нийттэй харилцах дотоод сүлжээ, мэдээлэл технологи хариуцсан ажилтныг томилж хавсран гүйцэтгүүлж байна. Хэрэгжилт-100
1.2.3	Албан хэрэг хөтлөлт, дотоод удирдлагын программ хангамжийг нэвтрүүлж, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн албан бичгийг цахимаар солилцож хэвших		-Тоон гарын үсгээр баталгаажуулан илгээсэн албан бичгийн тоо -DocX системд холбогдсон эсэх	-	Байгууллагын үйл ажиллагаанд цахим системийг тогтмол ашиглаж хэвшсэн байна.	Газрын даргын тоон гарын үсгийг баталгаажуулж байгууллагын албан үйл ажиллагаанд DocX системд холбох ажлыг хийж гүйцэтгэж байна. Хэрэгжилт-100
1.2.4	"Цахим жишиг аймаг" хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн "Go Uvurkhangaï" аппликэйшныг олон нийтэд сурталчилан таниулж, байгууллагын амдинаар дамжуулан мэдээ, мэдээллийг тогтмол байршуулах		-Мэдээ, мэдээллийн тоо -Хэрэглэгчийн тоо	-	Нэг сувгаар төрийн мэдээ, мэдээллийг дамжуулан хэрэглэгчийн тоо нэмэгдсэн байна.	"Go Uvurkhangaï" аппликэйшиныг байгууллагын веб хуудас болох Nature.ov.gov.mn -аар дамжуулан хэрэглээ, өргөдөл гомдол, аюул зөрчлийн мэдэгдэх зэрэг боломжуудын талаар мэдээ, мэдээлэл хүргэж ажилласан. Хэрэгжилт-100 хувь
1.2.5	Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрөх, нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах		-Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангасан эсэх	-	Хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэх боломжийг нэмэгдүүлж, цаг хугацаа хэмнэн зардлыг бууруулж, төрийн үйлчилгээг түргэн, шуурхай	Байгууллагын үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах ажлын хүрээнд байгууллагын Nature@ov.gov.mn , uvurkhangaïnature@gmail.com , erp.uvurkhangaï.gov.mn болон Emongolia.mn цахим хаягаар 352 албан бичгийг хүлээн авч хариу хүргүүлсэн бөгөөд цахим хаягаар хүлээн авсан хариу хүргүүлсэн бичиг нь тухай газрын нийт албан бичгийн 68 хувийг эзэлж байна.

					үзүүлж ажилласан байна.	Хэрэгжилт-100 хувь
1.2.6	Нийтийн мэдээлэл хариуцагч байгууллага бүр кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, кибер аюулгүй байдлын дотоод журмыг баталж, мөрдөх		-Кибер аюулгүй байдлын дотоод журам баталсан эсэх	-	кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Кибер аюулгүй байдлын дотоод журмыг газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн А/10 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж, мөрдлөг болгон ажиллаж байна. Хэрэгжилт-100 хувь
1.2.7	Төрийн үйлчилгээнд цахим технологийн хэрэглээг нэмэгдүүлэх үзүүлж буй үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах сургалт, өдөрлөгийг тогтмол зохион байгуулах		-Цахимд шилжсэн үйлчилгээний тоо -Иргэдэд хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар сурталчилж ажилласан байдал болон цахим үйлчилгээ авсан иргэдийн тоо	-	Төрийн үйлчилгээг цахимжуулж, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна. Цахим үйлчилгээ авсан иргэдийн тоо нэмэгдсэн байна.	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх хүрээнд ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гүн өрмийн худаг гаргах зөвшөөрөл, усны мэргэжлийн байгууллагын эрх олгох дүгнэлт, аймгийн Засаг даргын тодорхойлолт зэрэг 5 төрлийн үйлчилгээг цахимжуулж, "E-MONGOLIA" СИСТЕМД-д шилжүүлсэн. 2025 онд уг үйлчилгээг иргэдэд сурталчлах ажлыг байгууллагын вэйб сайт, пэйж хуудас, нээлттэй хаалганы өдөрлөгөөр зохион байгуулсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 51 иргэн цахимаар үйлчилгээ авсан. Хэрэгжилт-100 хувь
1.2.8	Байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, түүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэн тайланг харьяа бодлогын хэлтэст ирүүлэх		-Сэтгэл ханамжийн судалгаа авсан эсэх -Судалгаанд тулгуурлан авч хэрэгжүүлсэн ажлын үр дүн	-	Байгууллагын үйл ажиллагааны чанар сайжирч, иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн байна.	Байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг https://nature.ov.gov.mn сайтаар авч байна. Хэрэгжилт-85 хувь
Зорилт 1.3.Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан байна.						
1.3.1	Аймгийн Засаг даргын 2021 оны А/561 дүгээр захирамжаар батлагдсан	-	-Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл,	-		-Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд албан хаагчдын ажиллах нөхцлийг

	“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн, хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгох		нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал			сайжруулах зорилгоор 2 өрөөнд бүрэн засвар хийж тохижуулан 4 мэргэжилтний компьютер, техник хэрэгсэлийг шинэчилсэн. Дээрх арга хэмжээнд байгууллагын төсөв болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 27,5 сая төгрөг зарцууллаа. -Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын дагуу орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж, төрийн захиргааны албан тушаалд тасралтгүй 5 жил (60 сар), түүнээс дээш хугацаагаар ажилласан 1 мэргэжилтэнд 5 жилийн тэтгэмж олголоо. Баруунбаян-Улаан сумын байгаль хамгаалагч өндөр насны тэтгэвэрт гарах болзол хангаж, тэтгэмжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгон, өөрийн хүсэлтийн дагуу төрийн албанаас чөлөөлсөн. -Тус газрын мэргэжилтнүүдээс удирдлагын академийн богино хугацааны төлбөртэй сургалтад 2 мэргэжилтэнг хамруулж, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад газрын дарга болон 1 мэргэжилтэн хамрагдаж төгссөн. Тус газрын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлж дүгнэн “Хангалттай сайн” үнэлгээ авсан албан хаагчдад эхний хагас жилийн үр дүнгийн урамшуулал олгосон. Хэрэгжилт-100 хувь
				Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг батлагдсан аргачлалын дагуу үнэлж, дүгнэсэн байна. Төрийн албан хаагчтай холбоотой ёс зүйн зөрчлийн тоо буурсан байна.		
			-Төрийн албан хаагчтай холбоотой ёс зүйн зөрчлийн бууралтын тоо -Байгууллагын ёс зүйн зөвлөл, дотоод хяналт шалгалтын ажлын чанар			-Энэ оны байдлаар тус газрын албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой зөрчил гараагүй. -Байгууллагын дотоод хяналтын нэгжийн 2025 оны төлөвлөгөөг газрын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. 2025 оны 3,5,9,12 дугаар сард бүх сумдыг хамруулан дотоод хяналт шалгалт зохион

						байгуулж, сумдын удирдлагууд болон холбогдох албан хаагчдад Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын талаар сургалт зохион байгуулж, сумдад 2025 онд хийгдсэн ажил болон 2026 оны арга хэмжээний төлөвлөлт, байгаль орчны төсөв мэдээллийн сангийн программын ашиглалтад хяналт үнэлгээ хийж, мэргэшил арга зүйгээр хангаж зөвлөн туслах ажил зохион байгууллаа.
						-Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, Бат-Өлзий суман дахь Сум дундын Ойн анги, сумдын Байгаль хамгаалагч нарын үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулж, заавар зөвлөгөө өгч ажилласан. Хэрэгжилт-100 хувь
1.3.2	Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тохиолдолд холбогдох баримт бичгийг баталгаажуулах, нийгмийн баталгааг дордуулахгүй байх	-	-Албан тушаалын тодорхойлолтод тавигдах тусгай шаардлагыг хангасан байдал -шилжүүлэх, сэлгэн ажиллуулах судалгааг хугацаанд нь ирүүлсэн байдал	-	Шилжүүлэх, сэлгэн ажиллуулах томилгоотой холбоотой шийдвэр хууль тогтоомжид нийцсэн байна. Гомдол зөрчил гаргаагүй байна.	Энэ онд 2 мэргэжилтнийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн томилсон. Хэрэгжилт-100 хувь
1.3.4	Төрийн үйлчилгээний байгууллагын гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог аймгийн нэгдсэн сайтаар дамжуулан олон нийтэд мэдээллэх	-	-Сул орон тоог нээлттэй зарласан байдал -Сонгон шалгаруулалтын тоо	-	-Сонгон шалгаруулалтыг ил, тод, нээлттэй зохион байгуулсан байна.	Тус газрын нягтлан бодогч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн тул түүний оронд төрийн бусад байгууллагад ажиллаж байгаа нягтлан бодогчийг томилж хавсран гүйцэтгүүлж байна. Хэрэгжилт-100 хувь

					-Томилгоотой холбоотой маргаан гараагүй байна.	
					Хэсгийн дундаж үнэлгээ	98,4 хувь
					Ерөнхий үнэлгээ	97,7 хувь

БИЕЛЭЛТ ХЯНАСАН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА

Т.ЭРДЭНЭБАЯР

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ-ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

В. Золзаяа

Э.ЗОЛЗАЯА